

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТИН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая. төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1.	Хөгжлийн бодлогын баримт бичийн хэрэгжилтийн явцын тайланд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. ЗГ-ын 2020 оны 206-р тогтоол "ХШҮ хийх нийтлэг журам"-ын 7.6.1, 7.6.3, 7.6.4	-	-Тайлангийн тоо, - Цахим системд байршуулсан эсэх	2023 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан	Тайлангийн тоо-3 -Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050" -Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хийсэн ХШҮ-ний тайланг ЗГХЭГ, ЭЗХЯ-нд хүргүүлнэ. www.new.unelgee.gov.mn системд байршуулсан байна.)	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичийн хэрэгжилт дунджаар 86.9 хувьтай, 100 хувьтай 40 арга хэмжээ, 70-90 хувьтай 38 арга хэмжээ, 30-50 хувьтай 4 хэмжээ, 0 хувьтай 4 арга хэмжээ үнэлэгдсэн. Тайланг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр цахимаар болон 9 дүгээр сарын 19-ний өдрийн 3/484 тоот албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 41.0, хувьтай, 100 хувьтай 1 арга хэмжээ, 70-90 хувьтай 1 арга хэмжээ, 30 хувьтай 5 хэмжээ, 0 хувьтай 1 арга хэмжээ үнэлэгдсэн. Тайланг 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдөр цахимаар болон 3/1626 тоот албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн	100
2.	Яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. ЗГ-ын 2020 оны 206-р тогтоол "ХШҮ хийх нийтлэг журам"-ын 9.1.1	-	Тайлангийн тоо	2022 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан	Тайлангийн тоо-1	Яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний 56 арга хэмжээний биелэлт дунджаар 83.4 хувьтай, 90-100 хувьтай 37 арга хэмжээ, 70 хувьтай 11 арга хэмжээ, 30-50 хувьтай 8 арга хэмжээ үнэлэгдсэн. Стратеги төлөвлөгөөний биелэлтийг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хурлаар 7 дугаар сард хэлэлцүүлж, холбогдох нэгжүүдэд үүрэг даалгавар өгсөн.	100

3.	Мэдээллийн ил тод байдлыг хангаж дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг цаглаварт хугацаанд яамны цахим хуудсанд байршуулах Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	-	Яамны цахим хуудсанд байршуулсан эсэх	2023 онд гүйцэтгэсэн ХШҮ, ДА-ын 15 тайлан	Яамны цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангасан байна.	Яамны цахим хуудсанд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захирагааны Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9.11-д заасны дагуу "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Сайдын эрхлэх асуудлыг хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан"-г байршуулсан.	100
4.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. ЗГ-ын 2020 оны 206-р тогтоол "ХШҮ хийх нийтлэг журам"-ын 8.1	-	Тайлангийн тоо, Холбогдох байгууллага д хүргүүлэх, Цахим системд байршуулсан эсэх	2023 оны хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайлан	Тайлангийн тоо-1 ЗГХХГ-т хүргүүлж, www.new.unelgee.gov.mn цахим системд байршуулсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 9 дүгээр сарын 188 заалтын хэрэгжилт дунджаар 78.3 хувь, 10 дугаар сарын 243 заалтын хэрэгжилт дунджаар 75.1, хувь, 11 дүгээр сарын 243 заалтын хэрэгжилт 75.1 хувьтай үнэлэгдсэн. Тайланг 2024 оны 9, 10, 11 дүгээр сарын 10-ны өдөр цахимаар new.unelgee.gov.mn системээр тайлагнасан.	100
5.	Салбарын жендерийн бодлого, стратегийн тухайн жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	-	Тайлангийн тоо	Салбарын жендерийн суурь судалгаа	Тайлангийн тоо – 1	ЗГХА СҮГ болон БТСУХ-нд 11 сарын 14-ний өдрийн 10/1041 тоот "Жендерийн тайлан ирүүлэх тухай" албан бичгийг хүргүүлсэн. Тус албан бичгийн хариу БТСУХ-ны 12 дугаар сарын 5-ны өдрийн 1/1211 тоот албан бичгээр ирүүлсэн боловч мэдээлэл дутуу, шаардлага хангахгүй байсан тул буцаав.	50
6.	Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж,	-	Тайлангийн тоо, Холбогдох байгууллага	2022 оны үйл ажиллагаан	Тайлангийн тоо-1	Соёлын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн 230 арга хэмжээний биелэлтийг үнэлэхэд 90-100 хувьтай 148, 70 хувьтай 38, 30-50	100

	дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. ЗГ-ын 2020 оны 206-р тогтоол "ХШҮ хийх нийтлэг журам"-ын 9.1.1		д хүргүүлэх, Цахим системд байршуулах	ы ХШҮ-ний тайлан	Удирдлагад танилцуулсан тайлангийн тоо-1	хувьтай 44 арга хэмжээ дундаж үнэлгээ 83.7 хувь буюу 4.2 оноотой цаашид "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэхээр сайдын албан даалгавар 3-ыг боловсруулж батлуулсан. Тус албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж сайдад илтгэх хуудсаар танилцуулсан.	
7.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, нийслэлийн СҮГ, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. ЗГ-ын 2020 оны 206-р тогтоол "ХШҮ хийх нийтлэг журам"-ын 9.5	-	Тайлангийн тоо, Цахим системд байршуулса н эсэх	2023 оны ХШҮ-ний тайлан	Тайлангийн тоо - 1, ССАЖЗ-ын салбарын харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж www.moc.igovernment.mn цахим системд үнэлсэн байна.	Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа 26 байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн 709 арга хэмжээний биелэлтийг үнэлэхэд 90.0 хувь буюу 4.5 оноотой цаашид "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. Харьяа 26 байгууллагаас 16 байгууллага 80-89 хувьтай, 10 байгууллага 90-100 хувьтай үнэлэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 6 дугаар сарын 25-ны өдөр сайдад илтгэх хуудсаар танилцуулсан.	100
8.	Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хангах Засгийн газрын 2015 оны 483-р тогтоол "Дотоод аудитын дурэм"-ийн 7.1, 7.9	-	- Төлөвлөгөө батлагдсан эсэх - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Дотоод аудитын хорооны 2022-2024 оны дунд хугацааны төлөвлөгөө, тайлан	-Батлагдсан төлөвлөгөө -1 -Төлөвлөгөөний хэрэгжилт 100%	Дотоод аудитын хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгээ 3 зорилтын хүрээнд 7. арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар боловсруулж Сайдаар батлуулсан. Дотоод аудитын хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн дотоод аудитын 8, дотоод хяналт шалгалтын 2 тайланг танилцуулан холбогдох шийдвэр, тогтоол гаргуулан, шалгагдагч байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Дотоод аудитаар санхүүгийн тайлагнал, цалингийн зардлын бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, Шилэн дансны	90

						тухай хуулийн хэрэгжүүлтийн талаар холбогдох хууль, тогтоомжийг мөрдөөгүй 199.9 сая төгрөгийн 20 удаагийн алдаа дутагдал илрүүлж, түүнийг цаашид залруулах, давтан гаргахгүй байх талаар 17 зөвлөмж, 4 албан шаардлагыг тайлангаар хүргүүлж хяналтад авсан.	
9.	Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт,	-	Тайлангийн тоо	-	Тайлангийн тоо - 1	<p>1. Засгийн газрын 2023 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам", Засгийн газрын 2022 оны 268 дугаар тогтоолоор баталсан "Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд мөнгөн урамшуулал олгох журам"-ын хэрэгжилтэд санхүүгийн болон нийцлийн аудит хийж үр дүнг үнэлж, санал дүгнэлт гаргахаар удирдамж батлуулан харьяа байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>2. Дотоод аудит хийх аргазүй олгох сургалтыг аймгийн СУГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн, дотоод хяналтын ажилтан нарын хамруулан 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>3. Салбарын хэмжээнд 2022-2023 онд үзмэртэй шууд харьцах албан тушаалтны урамшууллын зардалд батлагдсан 686,378.2 мянган төгрөгийг музейн 72 ажилтанд олгосон, орон нутгийн таван жилийн тэтгэмжийн зардалд батлагдсан 8,832,073.0 мянган төгрөгийг 2291 албан хаагчдад олгосон дүн мэдээ гарсан.</p>	90
10.	Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын дүгнэлтэд үндэслэн	-	Тайлангийн тоо	-	Тайлангийн тоо - 1	Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт олгогдсоноор соёлын байгууллагуудын санхүүжүүлэх боломжгүй хүлээгдэж байсан уран бүтээл болон эрдэм	100

албан шаардлага гаргах,
хэрэгжилтийг хангуулах.
Төсвийн тухай хуулийн 69.3
дахь заалт,

шинжилгээний ажил боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломж, байгууллагын дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад нэн шаардлагатай байсан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж, 2022 оны ажлын үр дүнгээ үнэлүүлж тодорхой хувь урамшуулалт авсан, ажилдаа үнэнч байх илүү сэтгэл хангалийн болсон гэх зэрэг сайн үр дүнгүүд гарсан байна.

Хөтөлбөр арга хэмжээний зардлыг 4 байгууллага нийт 21,860.6 мянган төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан.

Мөн хөтөлбөр арга хэмжээний зардлыг 16 байгууллага, байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтын зардлыг 164 байгууллага, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардлыг 23 байгууллага, ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулалт олгох зардлыг 11 байгууллага нийт 214 байгууллага нь зардлуудын хувь хэмжээг баримтлаагүй.

Тиймээс тус аудитын илэрсэн асуудалд нь СХШ-ын улсын байцаагчийн 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Зөрчил арилгуулах тухай" 03 дугаар албан шаардлага ёгч, хэрэгжилтийг Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 15 Соёл, урлагийн газрууд албан бичгээр ирүүлсэн байна.

						Харин Баян-өлгий Говь-Алтай, Дундговь, Завхан, Увс, аймгийн 5 Соёл урлагийн газрууд хэрэгжилтийг ирүүлээгүй байна. Албан шаардлагын хэрэгжилт 71 хувьтай байна.	
11.	Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжээр салбарын харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд зөвшлилцсний үндсэн дээр дотоод аudit, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгүүлж, үр дүнг тооцох. Засгийн газрын 2015 оны 483-р тогтоол "Дотоод аудитын дүрэм"-ийн 4.11	-	- Тайланийн тоо - Санхүүгийн хяналт шалгалт хийгдсэн байгууллагын тоо	-	- Тайланийн тоо - 1 - Санхүүгийн хяналт шалгалт хийгдсэн байгууллагын тоо-50	ССАЖЗ-ын сайдын баталсан 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн "... Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж"-ын дагуу соёлын салбарын 162 байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн 21 аймгийн аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албадын санхүүгийн хяналт шалгалтын тайлан болон илэрсэн асуудлын тоон мэдээг нэгтгэн Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албадын хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар нийт 188,708.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: • 29,241.5 мянган төгрөгийн 41 төлбөрийн акт; • 83,619.8 мянган төгрөгийн 20 албан шаардлага; • 75,846.8 мянган төгрөгийн 112 зөвлөмжийг ёгсөн байна.	90
12.	Соёлын салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын хетөлбөрийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт	-	Тайланийн тоо	Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын аудит	Гүйцэтгэлийн аудитын тайлангийн тоо-1,	Соёлын салбарын 2024 оны улсын төсвийн хөрөнгө үр дүн сэдэвт дотоод аудитын дүнгээр худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хуулийн хүрээнд харьяа байгууллагуудын хэмжээнд нэгтгэн төлөвлөж, батлуулаагүй, худалдан	70

						авах ажиллагааны зарим ажлын төсвийн гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтын үр нөлөөгүй байгаа тул дотоод хяналтыг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт өгсөн.	
13.	Харьяа байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт	-	Тайлангийн тоо	Харьяа 14 байгууллага д аудит хийсэн тайлан	Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын тайлангийн тоо-2 - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, - Кино урлагийг дэмжих сан	ССАЖЗ-ын сайдаар Кино урлагийг дэмжих сангийн 2024 оны III улирлын байдлаарх төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх удирдамжийг батлуулж, нийт 27 төсөл арга хэмжээний 3,608,493.7 мянган төгрөгийн олгосон санхүүжилтэд дотоод аудит гүйцэтгэсэн. Нийт 27 төсөл, арга хэмжээнээс: •Бүрэн дууссан 15 төсөл, арга хэмжээ; •Олон улсын наадамд 5 төсөл арга хэмжээ оролцсон; •Мөн сангаас санхүүжсэн төсөл, арга хэмжээнүүд нь давхардсан тоогоор 31 кино театрт 566,000 үзэгчдэд толилуулжээ. Аудитаар дараах илэрсэн зөрчилд зөвлөмж өгөгдлөө. Үүнд: - ажил гүйцэтгэх гэрээний дагуу 4 төсөл хэрэгжүүлэгчид гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн тайланг тайлагнаагүй. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг соёл, урлагийн газрын 2024 оны III улирлын байдлаарх төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын удирдамжийг сайдаар батлуулсан. Тус байгууллага нь 2024 онд 736,923.4 мянган төгрөгөөр төсөв батлагдаж, хагас жилийн байдлаар 383,567.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 6,318,000.0 мянган төгрөгийн орлого орж, 3,519,199.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	70

					Соёлын сайд /хуучин эрээр/-ын 2024 оны "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" А/53, А/81, А/85, А/123, А/128, А/130, А/219, А/252, А/265, А/279 дүгээр тушаалуудаар нийт 6,543,000.0 мянган төгрөгийн олгосон санхүүжилтэд аудитыг гүйцэтгэж байна.		
14.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын Шилэн дансны хөтлөлтөд нийцлийн аudit хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт, Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь заалт	-	Тайлангийн тоо	2022 онд хийсэн дотоод аудитын тайлан	Тайлангийн тоо-2 Харьяа байгууллагуудын 2023 оны болон 2024 оны хагас жилийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт салбарын харьяа 450 байгууллагын хэмжээнд 88.1 хувтай дүгнэгдэв. Дотоод аудитын дүнгээр салбарын харьяа байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг 2206 удаа хугацаа хоцроож, 44,498.4 сая төгрөгийн 4661 удаагийн мэдээллийг мэдээлээгүй алдаа дутагдал гаргасан тул цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт ёгсэн.	100
15.	Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аudit хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Төрийн аудитын тухай хуулийн 20.3, Сангийн сайдын 20219 оны 29-р тушаал Дотоод аудитын хорооны дүрмийн 4.1.4	-	Тайлангийн тоо	-	Тайлангийн тоо-1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлберийн 11 зорилт 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 13,199.8 сая төгрөгийн төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 9 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 8,283.2 сая төгрөгийн 68 гэрээ байгуулж, 5,025.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Харин 21 арга хэмжээнд төсөвлөсөн 4,916.6 сая төгрөгийн төсөв зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд гэрээ хийгдсэн 43 арга хэмжээнээс 7 ажлын гэрээ дүгнэгдэж 1,019.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, 36 арга хэмжээний гэрээний урьдчилгаа 4,006.3 сая төгрөг олгож, гэрээний хугацаа дууссан байхад 3,257.8 сая	100

					<p>төгрөгийн санхүүжлийг олгоогүй, гэрээний хугацаа зөрчсөн байна.</p> <p>Улсын төсөвт батлагдсан аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын 8 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 58.3 хувьтай гэж дүгнэв.</p> <p>Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, захиалагч БОАЖЯ /хуучин нэрээр/, гэрээний дагуу төсвийн зарцуулалтын эрх хүлээсэн АЖМХ болон гүйцэтгэгч байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 398.0 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн.</p>		
16.	Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлгаха. Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт	-	Тайлангийн тоо	2023 онд 3 байгууллага д хяналт шалгалт хийсэн.	Тайлангийн тоо - 1	<p>Биеийн тамир спортын салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 10 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 68,871.7 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийж, төлөвлөгөөний хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдэв.</p> <p>Улсын төсөвт батлагдсан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын 20 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 60.0 хувьтай гэж дүгнэв.</p> <p>Биеийн тамир, спортын улсын хорооны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд 589.9 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн.</p>	100

17.	Үндэсний шигшээ багуудын 2024 оны төсөв, гүйцэтгэлийн үр дүнд дотоод аudit хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт	-	Тайлангийн тоо	-	Тайлангийн тоо-1	Соёл, спорт, аялуп жуулчлал, запуучуудын сайдын 2024.09.12-ны өдрийн “Биеийн тамир, спортын салбарын төсөв санхүү, хөрөнгө оруулалтын үр дүнд дотоод аudit хийж” баталсан удирдамжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ. Дотоод аудитаар үндэсний шигшээ багийн 26 төрлийн 333 дасгалжуулагч, тамирчдын 2024 оны 1-ээс 9-р сарын 5,491.2 сая төгрөгийн цалингийн зардал, гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд нийгмийн даатгалын болон татварын байгууллагад тайлагнахтай холбоотой 388.7 сая төгрөгийн 3 зөрчил, үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчийн цалингийн тооцоо, бүртгэлтэй холбоотой 134.5 сая төгрөгийн 7 зөрчил тус тус илэрч нийт 523.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 21 холбоонд 33 зөвлөмж хургуулсан.	100
18.	Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл гомдол, хүсэлт, удирдах дээд шатны байгууллагын удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, тайлагнах. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5²-р зүйл, Төсвийн тухай хуулийн 69.3 дахь заалт	-	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэс эн хувь	УАГ-аас өгсөн зөвлөмжийн биелэлтийн тайлан	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100 хувь	Байгалийн түүхийн музейн ажилтан Г.Гантувшинээс ССАЖЗ-ын сайдад 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гаргасан гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд Музейн захирал И.Будбаярын гаргасан шийдвэртэй холбоотой гомдолд дурдагдсан 13 асуудлын талаар холбогдох санхүүгийн баримт, үйл ажиллагааны тайланг хянаж, хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй биечлэн танилцан, зарим албан тушаалтнаас тайлбар авч дүн шинжилгээ хийн хяналт шалгалтыг дүгнэхэд гомдол гаргагчийн хөндсөн асуудлын 50 хувь үндэслэлтэй болох нь тогтоогдсон байна. Хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн зөрчил арилгуулахаар 5 заалт бухий	100

					хугацаатай албан шаардлагыг тус байгууллагын удирдлагад хүргүүлсэн.		
19.	Хөндлөнгийн аудит, дотоод аудитын тайлангаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, ҮАГ-т тайлагнах. Төрийн аудитын тухай хуулийн 20.3, Сангийн сайдын 20219 оны 29-р тушаал Дотоод аудитын хорооны дүрмийн 4.1.4	-	зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хүлээн авч, тайлагнасан эсэх	ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн биелэлтийн тайлан	Дотоод аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хүлээн авч, хяналт тавьсан байна. Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т тайлагнасан байна.	<p>1. ҮАГ-аас санхүүгийн нэгтгэсэн аудитын тайлангаар ирүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж Төрийн аудитын тухай хуулийн 20.5-д заасны дагуу хуулийн хугацаанд тус байгууллагад ССАЖЗ-ын сайдын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 1/300 дугаар албан бичгээр хүргүүлж тайлагнасан.</p> <p>2. "Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан"-аар тогтоосон төлбөрийн акт, зөрчил арилгуулах албан шаардлага, хууль тогтоомжийг мөрдүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, албан даалгаврын биелэлтийг гаргаж удирдлагад танилцуулсан.</p> <p>3.3Г-ын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 01/752 дугаар "Мэдээлэл ирүүлэх тухай" албан бичгийн дагуу</p> <ul style="list-style-type: none"> ✓ "Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан", ✓ "ҮАГ-ын 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан", ✓ "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны төрийн 	100

					<p>нарийн бичгийн даргын 2024 оны "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ажлын байрны нэр, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тоог шинэчлэн батлах тухай" А/05 дугаар тушаал",</p> <p>✓ "Дотоод аудитын 2022, 2023 оны төлөвлөгөө, тайлан", "Санхүүгийн дотоод хяналт шалгалтын 2022, 2023 оны зөрчлийн мэдээлэл, нэгтгэл",</p> <p>"Соёлын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022, 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан" баримт бичгийн бэлтгэн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 3/672 дугаар албан бичгээр хургуулсан.</p>		
20.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг сайжруулах чиглэлээр салбарын хэмжээнд удирдах болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах.	10.0	Сургалтын тоо	2023 онд зохион байгуулсан сургалт	Сургалтын тоо-1	<p>1. Төв, орон нутгийн харьяа байгууллагын ХШҮ хариуцсан ажилтан нарын сургалтыг ТНБД-ын 2024 оны А/85 дугаар тушаалаар сургалтын хөтөлбөрийг батлуулан зохион байгуулсан. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Аудитын тухай хууль, Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын ўйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хүрээнд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга зүй эзэмшиүүлэх зорилготой сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Сургалтад Соёлын яам болон харьяа байгууллага, орон нутаг, нийслэлийн Соёл, урлагийн газрууд, орон нутгийн соёлын салбарын бүх шатны байгууллага (музей, театр,</p>	100

номын сан, соёлын төв)-ын дарга, захирал, няглан бодогч, хяналт-шинжилгээ, тайлан төлөвлөгөө, дотоод хяналт хариуцсан албан хаагч нийт 570 /танхим 70, цахим 500/ албан хаагч хамрагдсан. Сургалтын үр нөлөөг дүгнэж салбарын 431 байгууллагын дотоод хяналтын нэгж, ажилтныг томилуулж, дотоод хяналтын журам, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан эрх зүйн орчныг бурдүүлэх ажлыг зохион байгууллаа.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нэгдсэн удирдамжаар хийх хяналт шалгалтын арга зүй олгох сургалтыг аймгийн 21 газрын албан хаагчдад 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгуулсан.

3. Дотоод аудитын дүнгээр илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид давтан гаргахгүй байх арга зүй, олгох сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Соёлын төв өргөөнд Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран зохион байгуулсан. Уг сургалтад 27 байгууллагын 32 албан хаагч хамрагдсан байна.

ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ

93.0

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ /

2024.12.10

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭЖЛИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	931. 065,165,1	60

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Сургалтад хамрагдах болон сургалт зохион байгуулах замаар дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт шалгалт хийх мэдлэг, чадвараа дээшлүүлнэ.	100%	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	
2	Удирдан зохион байгуулах	
3	Асуудал шийдвэрлэх	
4	Манлайлах	
5	Багаар ажиллах	
6	Харилцаа	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
6	Мэргэжлийн ур чадвар 1.	
7	Мэргэжлийн ур чадвар 2.	
8	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (нэмэлттүүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.) (70 хүртэлх оноо)	65,1
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (15 хүртэлх оноо)	15
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ) (15 хүртэлх оноо)	15
4	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	95,1
Нийт оноо:		90

Үнэлгээ өгсөн:

Төрийн нарийн бичгийн
даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч



/А.Даваажаргал/
(албан хаагчийн нэр)
2024.12.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга:

.....
(гэрийн үсэг)

/Д.Түмэндээмбэрэл/
(албан хаагчийн нэр)
2024.12.13 (огноо)



СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
Ц.АЛТАНХУЯГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ХАРИУЦСАН
ШИНЖЭЭЧ ЦАЛТАНХУЯГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
(IV УЛИРАЛ)

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.1. ЯАМ, АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ДОТООД АУДИТЫГ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ							
1.	Арга хэмжээ 1.1.1. Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Тайлангийн тоо Дотоод аудитын төлөвлөгөөний биелэлтийг ТЕЗ-д танилцуулж, Сангийн яаманд хүргүүлэх.	1 2023 оны ДА-ын үйл ажиллагааны тайлан	1 1	Дотоод аудитын хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгээг 3 зорилтын хурээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар боловсруулж Сайдаар батлуулсан. Дотоод аудитын хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2024 оны IV улирлын дүнгээр нэгдсэн удирдамжаар салбарын хэмжээний 5 дотоод аудит, харьяа байгууллага -1, тусгай сан -1, өргөдөл гомдлын дагуу 3, нийт 10 хяналт шалгалтыг гүйцэтгэн тайланг ТНБД-ын зөвлөлийн хуралд 2 удаа, Сайдад биечлэн 1, илтгэх хуудсаар 8 удаа танилцуулан холбогдох шийдвэр гаргуулан, шалгагдагч байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Дотоод аудитаар санхүүгийн тайлagnal, авлага, өглөг, цалингийн зардлын бүртгэл, зардлын ангилал, зориулалт, эд хөрөнгийн бүртгэл, худалдан авалтын хууль	10 12	70

					тогооомжийн хэрэгжилттэй холбоотой 1,33.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн аудитаар 2206 удаа хугацаа хоцроосон, мэдээллийн иж бүрэн, бодитой, үнэн зөв байх шаардлагыг хангаагүй 4661 удаагийн 44,498.1 сая төгрөгийн алдаа дутагдал илрүүлж, түүнийг цаашид запруулах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, албан шаардлагыг харьяа байгууллагуудад хүргүүлж хяналтад авсан.		
2.	Арга хэмжээ 1.1.2. Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлagnах.	Тайлангийн тоо Тайланг удирдлагад танилцуулан, тайлан, зөвлөмжийг шалгуулагч этгээдэд хүргүүлэх.	-	1 1	<p>1. Засгийн газрын 2023 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”, Засгийн газрын 2022 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд мөнгөн урамшуулалт олгох журам”-ын хэрэгжилтэд санхүүгийн болон нийцлийн аудит хийж үр дүнг үнэлж, санал дүгнэлт гаргахаар удирдамж батлуулан харьяа байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>2. Салбарын хэмжээнд 2022-2023 онд үзмэртэй шууд харьцах албан тушаалтны урамшууллын зардалд батлагдсан 686,378.2 мянган төгрөгийг музейн 72 ажилтанд олгосон, орон нутгийн таван жилийн тэтгэмжийн зардалд батлагдсан 8,832,073.0 мянган төгрөгийг 2291 албан хаагчдад олгосон дун мэдээ гарсан.</p> <p>3. Дотоод аудитаар Засгийн газрын 2023 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан журмын шаардлага хангаагүй Баянхонгор аймгийн Жинст сум, Өмнөговь аймгийн Сэврэй сумын Соёлын төв, Хэнтий аймгийн Чуулгын нэр бүхий 4 албан хаагчид 19.3 сая төгрөгийн тэтгэмж олгосон зөрчил илэрч албан шаардлага тогтоосон.</p>	10 12	70

3.	Арга хэмжээ 1.1.3. Соёлын салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	Тайлангийн тоо	1	1	Соёлын салбарын 2024 оны улсын төсвийн хөрөнгө үр дүн сэдэвт дотоод аудитын дүнгээр худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хуулийн хүрээнд харьяа байгууллагуудын хэмжээнд нэгтгэн төлөвлөж, батлуулаагүй, худалдан авах ажиллагааны зарим ажлын төсвийн гүйцэтгэлд тавих захиалгчийн хяналтын үр нөлөөгүй байгаа тул дотоод хяналтыг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн.	10 12	70
		Тайланг удирдлагад танилцуулах, тайлан, зөвлөмжийг шалгуулагч этгээдэд хүргүүлэх.	2021 оны ХО-ын аудитын тайлан	1			
4.	Арга хэмжээ 1.1.4. Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын Шилэн дансны хөтлөлтөд нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	Тайлангийн тоо	1	1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт салбарын харьяа 450 байгууллагын хэмжээнд 88.1 хувьтай дүгнэгдэв. Дотоод аудитын дүнгээр салбарын харьяа байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг 2206 удаа хугацаа хоцроож, 44,498.4 сая төгрөгийн 4661 удаагийн мэдээллийг мэдээлэгүй алдаа дутагдал гаргасан тул цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгсөн. Аудитаар илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах талаар 5 дугаартай албан шаардлага гаргаж 21 аймгийн СУАЖЗ-ын газарт хүргүүлсэн, аудитын тайланг сайдад илтгэх хуудсаар мэдээлсэн.	10 12	100
		Тайланг удирдлагад танилцуулах, тайлан, зөвлөмжийг шалгуулагч этгээдэд хүргүүлэх.	2023 оны Шилэн дансны аудитын тайлан	1			
5.	Арга хэмжээ 1.1.5. Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	Тайлангийн тоо	1	1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн 11 зорилт 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 13,199.8 сая төгрөгийн төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 9 зорилт 43 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 8,283.2 сая төгрөгийн 68 гэрээ байгуулж, 5,025.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Харин 21 арга хэмжээнд төсөвлөсөн 4,916.6 сая төгрөгийн төсөв зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд гэрээ хийгдсэн 43 арга хэмжээнээс 7 ажлын гэрээ дүгнэгдэж 1,019.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн	10 12	100
		Тайланг удирдлагад танилцуулах, тайлан, зөвлөмжийг шалгуулагч этгээдэд хүргүүлэх.	-	1			

					олгосон, 36 арга хэмжээний гэрээний урьдчилгаа 4,006.3 сая төгрөг олгож, гэрээний хугацаа дууссан байхад 3,257.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, гэрээний хугацаа зөрчсөн байна. Улсын төсөвт батлагдсан аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын 8 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 58.3 хувьтай гэж дүгнэв. Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, захиалагч БОАЖЯ /хуучин нэрээр/, гэрээний дагуу төсвийн зарцуулалтын эрх хүлээсэн АЖМХ болон гүйцэтгэгч байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 398.0 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт өгсөн. Аудитын тайланг дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн, сайдын 2024 оны 02 дугаар албан даалгавар гаргасан.		
6.	Арга хэмжээ 1.1.6. Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	Тайлангийн тоо	1	1	Биеийн тамир спортын салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 10 зорилт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл нь 2024 оны III улирлын байдлаар 68,871.7 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийж, төлөвлөгөөний хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдэв. Улсын төсөвт батлагдсан Биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын 20 ажлын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 60.0 хувьтай гэж дүгнэв. Биеийн тамир, спортын улсын хорооны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд 589.9 сая төгрөгийн санхүүгийн алдаа дутагдал илэрсэн тул хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтыг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлт гаргаж сайдад илтгэх хуудсаар мэдээлсэн.	10 12	100
		Тайланг удирдлагад танилцуулах, тайлан, зөвлөмжийг шалгуулагч этгээдэд хүргүүлэх.	-	1			

7.	Арга хэмжээ 1.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр дүнг сайжруулах чиглэлээр салбарын хэмжээнд удирдах болон хяналт- шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	1	1	1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нэгдсэн удирдамжаар хийх хяналт шалгалтын арга зүй олгох сургалтыг аймгийн 21 газрын 100 албан хаагчдад 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгуулсан. 2. Дотоод аудитын дүнгээр илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид давтан гаргахгүй байх арга зүй, олгох сургалтыг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Соёлын төв өргөөнд Санхүү, хөрөнгө оруулалтын газартай хамтран зохион байгуулсан. Уг сургалтад 27 байгууллагын 32 албан хаагч хамрагдсан байна. 3. Төв, орон нутгийн харьяа байгууллагын ХШҮ хариуцсан ажилтан нарын сургалтыг ТНБД-ыг 2024 оны А/85 дугаар тушаалаар 8.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулан зохион байгуулсан. Уг сургалтад танхимаар болон цахимаар 90 албан хаагч хамрагдсан.		
	XШҮ, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгууллагасан байх.	2023 онд зохион байгуулсан сургалт	1			10 12	100

1.2. УДИРДЛАГЫН ШИЙДВЭРЭЭР ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД АУДИТ ХИЙХ

1.	Арга хэмжээ 1.2.1. Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл гомдол, хүсэлт, удирдах дээд шатны байгууллагын удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, тайлагнах.	Тайлангийн тоо	1	1	Байгалийн түүхийн музейн ажилтан Г.Гантувшингээс ССАЖЗ-ын сайдад 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гаргасан гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд Музейн захирал И.Будбаярын гаргасан шийдвэртэй холбоотой гомдолд дурдагдсан 13 асуудлын талаар холбогдох санхүүгийн баримт, үйл ажиллагааны тайланг хянаж, хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй биечлэн танилцан, зарим албан тушаалтнаас тайлбар авч дүн шинжилгээ хийн хяналт шалгалтыг дүгнэхэд гомдол гаргагчийн хөндсөн асуудлын 50 хувь үндэслэлтэй болох нь тогтоогдсон. Хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн зөрчил арилгуулахаар 5 заалт бүхий 04 дүгээр албан шаардлагыг тус байгууллагын удирдлагад хүргүүлсэн. Шалгалтын дүнг сайдад илтгэх		
	Tайланг удирдлагад танилцуулан, тайлан, зөвлөмжийг шалгуулагч этгээдэд хүргүүлэх.		1			10 12	100

					хуудсаар танилцуулан, дүгнэлтэд үндэслэн ТЗҮГ-т үүрэг чиглэл өгөгдсөн.		
1.3. ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ БОЛОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ							
1.	Арга хэмжээ 1.3.1. Хөндлөнгийн аудит, дотоод аудитын тайлангаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, ҮАГ-т тайлагнах	Зөвлөмжийн биелэлтийг хүргүүлсэн эсэх	Зөвлөмжий н биелэлтий н тайлан	1	<p>1. ҮАГ-аас санхүүгийн нэгтгэсэн аудитын тайлангаар ирүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж Төрийн аудитын тухай хуулийн 20.5-д заасны дагуу хуулийн хугацаанд тус байгууллагад ССАЖЗ-ын сайдын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 1/300 дугаар албан бичгээр хүргүүлж тайлагнасан.</p> <p>2. “Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-аар тогтоосон төлбөрийн акт, зөрчил арилгуулах албан шаардлага, хууль тогтоомжийг мөрдүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, албан даалгаврын биелэлтийг гаргаж удирдлагад танилцуулсан.</p>	10 12	100

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ

3.1. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

1.	Арга хэмжээ 3.1.1. Мэдээллийн ил тод байдлыг хангаж дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг цаглаварт хугацаанд яамны цахим хуудсан байршуулах	Цахимд байршуулсан тайлангийн тоо	2023 онд цахимд байршуулсан тайлангийн тоо-5	2	Яамны цахим хуудсанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайланг байршуулах ажлын хүрээнд 2024 онд гүйцэтгэсэн дотоод аудитын хяналт шалгалтын нэр бүхий 10 байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үр дүнгийн товч тайланг бэлтгэн олон нийтэд мэдээлэх ажил тухай бүр хийгдэж байна.	10 12	70
3.2. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ							

1.	Арга хэмжээ 3.2.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Батлагдсан төлөвлөгөөний тоо	2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө	1	Яам шинээр байгуулагдсан тул Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн тодотгосон төлөвлөгөөг боловсруулж 10 дугаар сарын 01-ны өдөр газрын даргаар батлуулсан.	10 12	100
		Тайлангийн тоо	2023 оны гүйцэтгэлийн тайлан	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гарган Төрийн захиргааны удирдлагын газарт 12 дугаар сарын 9-ний өдөр хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 3.2.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Архивд хүлээлгэн өгсөн ботийн тоо	2023 онд дотоод аудитын 5 архивын боть өгсөн	5	Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, зааврын дагуу дотоод аудитын 2023 онд бэлтгэсэн тайлан, ажлын баримтыг архивын нэгж болгон эмхлэн боловсруулж архивын ажилтанд нийт 5 архивын баримтыг хүлээлгэн өгсөн.	10 12	100
3.	Арга хэмжээ 3.2.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	ХАСХОМ бөглөж баталгаажуулсан маягт	2023 онд ХАСХОМ бөглөж баталгаажуулсан маягт		1. Төрийн албан хаагчийн 2024 оны шинэчилсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 10 дугаар сарын 28-ны өдөр meduuleg.iaac.mn системээр гаргаж мэдүүлсэн 2. Дээд шатны байгууллага болон харьяа байгууллагуудаас ирүүлсэн 41 албан бичгийг шийдвэрлэж ажилласан. 3. Дотоод аудит, хяналт шалгалтын ажил гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах, удирдамж батлуулах үедээ 4 удаа хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж Хууль эрх зүйн хэлтсийн ажилтанд өгч бүртгүүлсэн. 4. Байгалийн түүхийн музейн ажилтнаас гаргасан өргөдлийн дагуу дагуу хяналт		

					шалгалт хийж тайлан дүгнэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1.	Арга хэмжээ 1.1 Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх болон дотоод хяналт, аудитын чиглэлээр сургалтад хамрагдах	Гадаад, дотоодын байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	2023 онд хамрагдсан сургалт	3	1. Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулсан 7:4:10 сургалтад 3 удаа хамрагдаж мэдээлэл авсан 2. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан 14 хоног тутмын яам хоорондын ХШУДАГ-ын мэдээлэл солилцох сургалтад 2 удаа хамрагдсан.	10 12	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАНХУЯГ / /

do 24. 12. 09

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
дарын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

**ДОТООД АУДИТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
Ц.АЛТАНХУЯГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН
ТҮВШНИЙГ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн огноо
	1	2	3		5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл		70 хүртэл
Зорилт 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ					
1	Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	54	7	61	
2	Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах.	54	7	61	
